

АГУУЛГА

НЭГ. ХУРААНГУЙ.....	3
1.1 Мод мухар алтны шороон ордын танилцуулга.....	3
1.2 Байгаль орчны өнөөгийн төлөв байдлын хураангуй.....	3
ХОЁР. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭ	Error! Bookmark not defined.
2.1 Хууль эрх зүй.....	Error! Bookmark not defined.
2.2 Стандарт норм, норматив.....	Error! Bookmark not defined.
ГУРАВ. ТӨСЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ТЕХНИК ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДЭСЛЭЛ.....	7
3.1 Төсөл хэрэгжүүлэгчийн талаарх товч танилцуулга.....	7
3.2 Төслийн талбайн байршил	7
3.3 Ашиглалтын системийн сонголт	9
3.4 Ашиглалтын дараалал	9
3.5 Ордын уул-техникийн нөхцөл	11
3.6 Техник технологийн сонголт.....	11
3.7 Төсөл хэрэгжих орчны дэд бүтэц.....	12
ДӨРӨВ. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ, ҮНЭЛГЭЭ	12
4.1 Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөллийг үнэлсэн арга зүй.....	12
4.2 Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөллийн үнэлгээ.....	13
4.3 Төслийн гол сөрөг нөлөөлөл	16
ТАВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	19
5.1 Эрх зүйн үндэслэл ба түүний гол шаардлага	19
5.2 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зорилго, хамрах хүрээ.....	20
5.3 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө.....	23
5.4 Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	29
5.5 Биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө.....	30
5.6 Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олох арга хэмжээний төлөвлөгөө	31
5.7 Түүх, соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө	32
5.8 Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө.....	33
5.9 Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө	35
5.10 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	38
5.11 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө.....	42
5.12 Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө	45
Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал	46
Дүгнэлт	



ЗУРАГ, ХҮСНЭГТИЙН ГАРЧГИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. MV-007104 тоот тусгай зөвшөөрлийн талбайн булангийн цэгүүд	7
Хүснэгт 2. Нөлөөллийн үнэлгээний систем	13
Хүснэгт 3.Нөлөөллийг үнэлэх	13
Хүснэгт 4.Төслөөс үүсэж болзошгүй сөрөг нөлөөлөл	14
Хүснэгт 5.Уурхайн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх гол сөрөг нөлөөлөл, өртөх орчин, нөлөөллийн эрчим	17
Зураг 1. Төслийн талбайн сансарын зураг	8
Зураг 2. Төслийн талбайн байршил.....	9
Зураг 3. Тухайн жилийн уулын ажлын дэвсгэр зураг.....	



НЭГ. ХУРААНГУЙ

1.1 Мод мухар алтны шороон ордын танилцуулга

“АУМ” ХХК нь Өвөрхангай аймгийн Уянга сумын нутагт орших Мод мухар нэртэй MV-007104 дугаартай тусгай зөвшөөрөл бүхий ордыг 2007 оны 11 сард “Эрэл” ХХК-аас авсан байна.

Харин “Өгөөмөр Өргөө” ХХК нь 184.10 га талбай, MV-007104 дугаартай тусгай зөвшөөрөл бүхий ордыг 2019 онд “АУМ” ХХК-аас авсан бөгөөд тус ашиглалтын тусгай зөвшөөрлийг үндэслэн алтны шороон ордын тодотгол хайгуулын ажлыг 2017 оны 05-р сарын 1-ээс 2017 оны 10-р сарын 20-ны дотор өөрийн хөрөнгөөр хийж гүйцэтгэсэн байна.

Уг “Мод мухар” нэртэй MV-007104 тоот тусгай зөвшөөрлийн талбайн нөөцийг анх ЭБМЗ-ийн 2010 оны 06-р сарын 04-ны өдрийн хурлын ХХ-07-08 тоот дүгнэлтийг үндэслэн гаргасан АМГ-ын даргын 2010 оны 06-р сарын 23-ны өдрийн 255 дугаар тушаалаар ордын нөөцийг бодитой В зэргээр 138.5 мян.м³ элс, алтны нөөцийг хими цэврээр 146.25 кг, ордын дундажаар 1056 мг/м³ агуулгатайгаар хүлээн авч ашигт малтмалын нөөцийн улсын нэгдсэн тоо бүртгэлд бүртгүүлсэн байна.

“Өгөөмөр Өргөө” ХХК нь 2017 онд нарийвчилсан хайгуул хийж нөөцийн тодотголыг ЭБМЗ-өөр хэлэлцүүлэн ЭБМЗ-ийн 2018 оны 07 дугаар сарын 09-ны өдрийн Н/99 дүгээр тушаалаар ордын нөөцийг бодитой В зэргээр 54.22 мян.м³ элс, алтны нөөцийг хими цэврээр 40.45 кг, ордын дундажаар 857.39 мг/м³ агуулгатайгаар хүлээн авч ашигт малтмалын нөөцийн улсын нэгдсэн тоо бүртгэлд нэмж бүртгүүлсэн байна.

1.2 Байгаль орчны өнөөгийн төлөв байдлын хураангуй

Физик газарзүйн нөхцөл

MV-007104 тоот тусгай зөвшөөрлийн талбай нь физик газарзүйн мужлалтаар Хангайн нурууны өмнөд хэсэг, түүний салбар Хар хуштын нуруу, Улаан нуруу, Хятрууны даваа, Улаан даваа орчмын нутгийг хамарна. Улаан нуруу, Улаан даваа орчмын уулс далайн түвшнээс 2996.0 м өргөгдсөн байна. Талбайн хэмжээнд дундаж өндөрлөгүүд нь Хятрууны нуруу 2675.0 м, Цохиотын нуруу 2764.0 м-ийн хэмжээнд хэлбэлзсэн байна.

Уур амьсгал

Агаарын температурын дундаж хэм нь нэгдүгээр сард -18.1⁰С, хамгийн хүйтэн нь -44 хэм хүрдэг. Жилийн хамгийн дулаан сар 7-р сар бөгөөд агаарын дундаж температур 20-25 хэм дулаан байдаг. Агаарын хоногийн дундаж температур +10⁰С ба түүнээс дээш байх өдрийн тоо 120-130 хоног, 30⁰С-аас ба түүнээс дээш температуртай өдрийн тоо 20-30, 7-р сарын агаарын



үнэмлэхүй их температур 30°C , -30°C ба түүнээс хүйтэн температуртай өдрийн тоо 40-50, нэгдүгээр сарын агаарын үнэмлэхүй бага температурын дундаж -34°C байна. Жилийн нар гийгүүлэх хугацаа өвлийн нэг өдөрт 6 цаг, зуны нэг өдөр 10 цаг, жилийн хугацаанд 3000-3200 цаг байна.

Агаарын чанар

Төслийн талбайд хамгийн ойр орших агаарын чанарын хяналт шинжилгээний цэг нь Өвөрхангай аймгийн төв Арвайхээр хотод байрлаж байна. Тус хяналт шинжилгээний цэгийн 2019 оны 12 дугаар сарын 31-ны хэмжилтээр Хүхэрлэг хий, Азотын давхар исэл, Том ширхэгт тоосонцор, Нүүрстөрөгчийн дутуу ислийн үзүүлэлтүүд¹ бүгд стандарт хэмжээнээс доогуур, хэвийн үзүүлэлттэй байна. Харин төслийн талбайд хийсэн хэмжилт судалгаагаар хүнд машин механизмын хөдөлгөөний нөлөөгөөр тоосжилт ихээр үүссэн байна.

Физик бохирдол, хог хаягдал

Төслийн талбайд хийсэн хээрийн судалгаанаас үзэхэд АУМ ХХК-ийн буюу өмнөх жилүүдийн олборлолт, тээвэрлэлт, уурхайн хотхон холбогдох барилга байгууламжын бүтээн байгуулалтын нөлөөгөөр гадрын гадарга, хөрс, ургамлан нөмрөг доройтолд өртсөн байна.

Геологийн тогтоц ба геоморфологи

Ордын орчимд доод-дунд девон, доод-дунд юра, доод цэрдийн болон дөрөвдөгчийн тунамал бялхмал бүрдэл, дунд-хожуу девон, түрүү ба хожуу пермийн гүний болон вулкан шургамал бүрдэлүүд үүсэж тархсан байна. Мод мухарын амны орд нь Өлтийн хөндийн хамгийн дээд баруун талаас орж дээрээ нилээд том 2 салаа үүсгэн тогтсон ам бөгөөд геологийн тогтоцоороо девоны тогтолцооны дээд зузаалаг болох Эрдэнэцогтын давхаргадасын чулуулаг болох саарал зануужин, олон найрлагатай зануужин, элсжингийн суналтай дүйцэж болно. Тус амны дээд 2 салааны хооронд тархсан Эрдэнэцогтын давхаргадас нь базальт, гранит-Базальтын болон хас, цахирын үеүдийг нилээд баялаг агуулсан байдаг.

MV-007104 тоот тусгай зөвшөөрлийн талбайн ойролцоо гадаргын урсацтай томоохон гол болох Онги гол урсдаг. Төслийн талбай нь Онги голоос шулуунаар 11 км зайтай тул гадаргын усанд үзүүлэх нөлөөлөл бага юм. Уурхайн нуурийн ус болон унд ахуйн усны хэрэглээний зориулалттай гүний худгаас дээж авч шинжлүүлэв.

Шүүрлийн ус: Химийн бүрэлдэхүүнээрээ гидрокарбонатын ангийн, кальцийн бүлгийн, 2-р төрлийн, цэнгэг, зөөлөн бохирдолтой ус байна. Шинжилгээний дүнг ГУЦЗАН-тай



харьцуулахад жинлэгдэх бодис ба аммонийн ионы хэмжээгээр “Их бохирдолтой” ангилалд хамаарч байна.

Худгийн ус: Химийн бүрэлдэхүүнээрээ гидрокарбонатын ангийн, кальцийн бүлгийн, 2-р төрлийн, цэнгэг, зөөлөн ус байна. Уг усанд шинжилсэн физик, химийн бүх үзүүлэлт нь “Ундны усны стандарт” MNS900:2005-ын шаардлага хангаж байна.

Хөрсөн бүрхэвч

Өвөрхангай аймгийн Уянга сумын нутагт орших “Мод мухар” нэртэй MV-007104 тоот тусгай зөвшөөрөл бүхий алтны шороон орд газар нь Монгол орны хөрс-био уур амьсгалын өндрийн бүсшил бүхий Хэнтийн муж, Хэнтийн захын 38-р тойрогт багтана. Уурхайлалтад өртөх талбайн газрын гадаргын олон янз байдал, геоморфологийн онцлогоос шалтгаалж ерөнхийдөө Хөнгөн шавранцар Хархүрэн, Чулуурхаг Хархүрэн, Харшороон хөрсний дэд хэв шинж тархсан. Ашиглалтын талбайн гадна баруун дээд хэсэгт буюу уулруугаа Уулын хээржсэн бараан хөрс тархсан байна.

Тус алтны шороон ордын нийт талбайн хэмжээ 184.10 га бөгөөд одоогийн байдлаар үүний 13.5 га талбай уурхайн ашиглалтын талбай, зам, уурхайн барилга байгууламжуудын нөлөөгөөр эвдрэлд орсон байна. Үүнээс одоогоор одоогоор 9.5 га талбайд биологийн нөхөн сэргээлт хийсэн байна.

Ургамлан нөмрөг

Төслийн талбай нь ургамалжилтын хувьд Монгол орны ургамал–газарзүйн Хангайн өндөр уулын ойт хээрийн тойрогт хамаарна. Төслийн талбайд болон түүний ойролцоо өвслөг ургамалт уулын шинэсэн ой, уулсын дээд хэсэг, бэл хажуугаар үетэн-алаг өвст, алаг өвс-үетэнт уулын хээрийн ургамалжилтын хэв шинж зонхилох бөгөөд уулсын хоорондох ам хөндийгөөр улалжит бүлгэмдэл тархаж байна.

Амьтны аймаг

“Мод мухар”-ын орд газар нь Монгол орны амьтны аймгийн газарзүйн мужлалын хувьд Хангайн тойрогт багтана². Хангайн тойрогт багтаж байгаа хээрийн хөхтөн амьтны бүлгэмдлээс үндсэн тэжээлийн хувьд ургамлын ногоон хэсгээр хооллогч, улирлын идэвхи нь ичээлдэг зонхилогч зүйл амьтад болох Дагуур огдой – *O.dahurica*, Монгол тарвага – *Marmota sibirica*, Сүүлэрхэг зурам – *Citellus undulatus*, орог зузаг – *Phodopus campbell*, байгаль шишүүхэй – *Cricetulus pseudogriseus*, сохор номин – *Myospalah aspalah*, хэргэлзийн оготно – *Microtus gregalis*,



цайвар үлийч – *Lasiopodomys brandtii*, хул чичүүл – *Meriones unguiculatus*, хярс үнэг – *Vulpes Corsac*, цав цагаан үен – *Mustela erminea* зэрэг амьтад тус байгалийн бүс бүслүүрт экологийн орчныг шүтэн амьдардаг³.

Тусгай хамгаалалттай газар нутаг

Төслийн талбай нь Хангайн нурууны өмнөд хэсэгт байрлах бөгөөд уурхайн талбайн ойролцоо улсын тусгай хамгаалалттай “Хангайн нуруу-байгалийн цогцолборт газар” орон нутгийн хамгаалалттай байгалийн унаган төрх, өвөрмөц тогтоц, түүх соёлын дурсгал бүхий Даянгийн нуруу, Уртын давааны өндөр, Битүүхэйн рашаан, Хүнгүйн мухар, Хүйсийн найман нуур зэрэг газрууд байрлана. Даянгийн нуруу уурхайн талбайгаас 12 км-ын зайтай, Уртын давааны өндөр 24 км, Битүүхэйн рашаан 20 км, Хүнгүйн мухар 34 км, Хүйсийн найман нуур 37 км-ын зайтай байрлана.

Түүх соёлын өв

“Өгөөмөр Өргөө” ХХК-ийн MV-007104 тоот тусгай зөвшөөрөлтэй талбайд болон түүний нөлөөллийн бүсэд өнөөгийн байдлаар ямар нэгэн түүх соёлын дурсгалт зүйл ба археологийн олдвортой газар байхгүй байна. Төслийн хамрах хүрээнд палеонтологийн дурсгал илрээгүй байна. Хэрэв цаашид төслийн хэрэгжилтийн явцад төслийн талбай болон түүний нөлөөллийн бүсэд ямар нэгэн палеонтологийн олдвор олоход үед холбогдох хууль тогтоомжид заасны дагуу засаг захиргааны байгууллага болон холбогдох байгууллага болох ШУА, Палеонтологийн хүрээлэн 70118283, Түүх угсаатны зүйн хүрээлэн 11-458305-д нэн даруй мэдэгдэж арга хэмжээ авах шаардлагатай.

Нийгэм эдийн засаг

Өвөрхангай аймгийн Уянга сум нь 1931 онд байгуулагдсан, хуучнаар Сайнноён хан аймгийн Ханхөгшиний хошуунд багтана. 2017 оны статистикийн үзүүлэлтээр Уянга сумын хэмжээнд нийт 2834 өрх айл байгаа нь аймгийн хэмжээнд өрхийн тоогоор 3-рт орж байгаа бөгөөд нэг өрхийн ам бүлийн тоо 2017 онд 3.3 байна. Одоогоор төсөлд нийт ажилчдын 50-аас доошгүй хувийг сум орон нутгийн ажилгүй иргэдээс авч ажиллуулж байна. Мөн нийгмийн хариуцлагын хүрээнд нийт 5 айлыг малжуулж өрхийн амьжиргааг дэмжиж, ойролцоох малчин айл өрхүүдээс мах, сүү сүүн бүтээгдэхүүн авч орон нутгийн иргэдтэй хамтран ажиллаж байна.



ХОЁР. ТӨСЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ТЕХНИК ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДЭСЛЭЛ

2.1 Төсөл хэрэгжүүлэгчийн талаарх товч танилцуулга

№	Үзүүлэлтүүд	Тайлбар
1	Аж ахуйн нэгжийн нэр	“Өгөөмөр Өргөө” ХХК
2	Улсын бүртгэлийн дугаар	1011001090
3	Регистрийн дугаар	2681404
4	Аж ахуйн нэгжийн хаяг	Өвөрхангай аймаг, Арвайхээр, 1-р баг, Сумын төв Өөрийн байранд Утас: 91957511
5	Тусгай зөвшөөрлийн дугаар	MV-007104
6	Талбайн хэмжээ, га	184.10
7	Талбайн байршил	Өвөрхангай аймаг, Уянга сум, Мод мухарын ам
8	Төслийн зорилго	Өвөрхангай аймгийн Уянга сумын нутагт орших Мод мухар нэртэй алтны шороон ордыг эдийн засгийн үр ашигтайгаар ашиглах, Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй холбогдох хууль, дүрэм журам, стандартын дагуу үйл ажиллагаагаа явуулж, улс орон нутагт татвар төлбөрүүдийг төлөх, хүрээлэн буй орчинд сөрөг нөлөөлөл багатайгаар олборлолт ашиглалт явуулах, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлт хийх, шинээр 34 хүний ажлын байр бий болгох, ордын үр ашгийг улс, орон нутаг болон төсөл хэрэгжүүлэгч компанид хүртээхэд уг төслийн зорилго оршино.
9	Төсөл хэрэгжих үе шат	"Өгөөмөр Өргөө" ХХК нь ажлын туршлага боловсон хүчин, техник, технологийн материаллаг бааздаа тулгуурлан Мод мухар алтны шороон ордыг 4 жилийн хугацаанд ашиглаж, нөхөн сэргээлтийг бүрэн хийж орон нутагт хүлээлгэн өгнө.

2.2 Төслийн талбайн байршил

Мод мухар нэртэй MV-007104 тоот тусгай зөвшөөрөлтэй талбайн нь нийт 184.10 га талбайг хамрах ба нийслэл Улаанбаатар хотоос 492 км, Өвөрхангай аймгийн төв Арвайхээр хотоос 61 км-т, Уянга сумын төвөөс 18 км-т, байр зүйн зургийн L-48-49-р планшетэд оршино.

Хүснэгт 1. MV-007104 тоот тусгай зөвшөөрлийн талбайн булангийн цэгүүд

Булангийн цэгийн дугаар	Газарзүйн солбицол, градус	
	Өргөрөг	Уртраг
1	46° 35' 26.66"	102° 17' 20.65"
2	46° 35' 26.66"	102° 16' 0.65"
3	46° 36' 1.66"	102° 16' 0.65"
4	46° 36' 1.66"	102° 17' 20.65"





Зураг 1. Төслийн талбайн сансрын зураг



Зураг 2. Төслийн талбайн байршил

2.3 Ашиглалтын системийн сонголт

“Мод мухар”-ын алтны шороон ордын геологийн тогтоц нь аллювийн гаралтай дундаж гүнд орших дэнжийн шороон орд болно. Төсөл захиалагчийн техникийн бааз суурь, ойр орчмын ижил төстэй ордуудад нийтлэг ашиглаж буй автотээвэртэй дотоод овоолготой ашиглалтын системээр үргэлжлүүлэн олборлоно. Хучаас хөрсийг экскаватор автосамосвалын хослолоор хуулж дотоод овоолгын ажлыг хийж гүйцэтгэнэ. Тунаах болон цэвэр нуурыг уурхайн одоогийн байгаа талбайд байршуулна.

Хөрсний доголын өндөр	5.0 м
Олборлолтын доголын өндөр	0.6-2.6 м
Доголын налуугийн өнцөг	50°
Ажлын доголын аюулгүйн берм	1.5
Авто замын өргөн	8 м

Уулын ажлын зохион байгуулалт: Уурхайд хөрс хуулж овоолох, элс олборлох, олборлосон элсийг угаан баяжуулах гэсэн үндсэн процессууд явагдана.

2.4 Ашиглалтын дараалал

Төлөвлөгөөт оны нээлт: “Өгөөмөр Өргөө” ХХК нь ордыг иж бүрэн элсний хаягдалгүй ашиглахын тулд ордыг урд хэсгээс 14-B-3 нөөцийн хэсэгшлийн зүүн хойд жигүүрээс нээж ашиглана. Бэлтгэл ажлын хүрээнд ил уурхай, хөрсний гадаад овоолго, технологийн ус болон



хаягдлын далан, угаах төхөөрөмжийн талбайн шимт хөрсийг хуулах, баяжуулах үйлдвэрийн элсний нөөцийг бэлтгэх, далан болон баяжуулах үйлдвэрийн талбайг байгуулах угсрах зэрэг ажлууд орно.

Үржил шимт хөрсний овоолго: Уурхайгаас нийт 117.08 мян.м³ үржил шимт хөрсийг гадаад овоолгод шилжүүлэх болно. Шимт хөрсийг утгуурт ачигчаар түрж, экскаватор автосамосвалын хослолоор ил уурхайн хүрээг дагуулан 50 м зайд овоолно. Шимт хөрсний овоолгын өндрийг **Газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулалт, хадгалалт MNS 5916:2008** стандартыг баримтлан ажиллах бөгөөд 5.0 м-ээс ихгүйгээр, ТЭЗҮ-д тооцоолсноор 3 м-н өндөртэй овоолно.

Хөрсний дотоод овоолго: Уурхайн олборлолт нь одоогийн байдлаар 14-B-3 блокын хучаас хөрсийг хуулж, алт агуулсан элсний давхаргыг олборлож хоосон орон зай үүсэн байгаа учир үргэлжлүүлэн хөрсний дотоод овоолго хийн уурхайг ажиллуулна. Энэ нь техникийн нөхөн сэргээлтийн ажлыг уулын ажилтай давхар явуулах таатай боломж олгож байна.

Овоолгын тоног төхөөрөмжийн сонголт, бүтээл:

Хоосон чулуулгийг экскаватор автосамосвалын хослолоор хуулж гадаад болон дотоод овоолгод тээвэртэй ашиглалтын системээр овоолгын ажлыг явуулах бөгөөд түүнийг түрж тэгшлэх, дагтаршуулах ажлыг SHANUI-D65 маркийн бульдозероор гүйцэтгэнэ. Бульдозер нь хөрсний овоолгыг түрж тэгшлэхээс гадна хаягдал багатай олборлох үүднээс алттай элсийг олборлож дууссан талбайн улыг түрж бөөгнүүлэх, тээвэрлэгдэн ирсэн эфель гаалийг түрэх, туслах тоног төхөөрөмжүүдийг шилжүүлэн зөөх, уурхайн дотор зам засах, экскаваторын суурь бэлдэж өгөх, траншей нэвтрэх гэх мэт бусад туслах ажлыг хийж гүйцэтгэнэ. Хөрс хуулалтын ажил жилд дунджаар 110.5 мян.м³. Япон улсад үйлдвэрлэсэн D61PX-23 маркийн бульдозерыг ашиглана.

Элс угаах процесс: Элсийг ил уурхайгаас автосамосвалаар тээвэрлэж элсний овоолгод буулгах ба DEAWOO 300LC маркийн экскаватороор угаах төхөөрөмжийн хүлээн авах бункерийг тэжээнэ. Элс угаах төхөөрөмжид өгөгдөж, хүрдэн шигшүүрт орж угаан ангилагдан задарч, торны дээрх (+20 мм) хоосон чулуулаг нь конвейероор дамжиж том ширхэгтэй чулуулаг/галь/-ийн овоолгод хураагдана. Хаягдлын цөөрөмд эфель тунаж, цэвэршсэн усыг эргүүлэн технологид ашиглана. Угаалга эхлэхэд технологийн усан хангамжийг гүний худгаас бүрэн хангах ба үйлдвэрлэлийн явцад усан хангамжийн 70%-ийг эргэлтийн усаар хангаж, үлдсэн 30% усыг цэвэр усаар нөхөн сэлбэхээр тооцсон байна.



2.5 Ордын уул-техникийн нөхцөл

Мод мухарын алтны шороон орд нь бага гүнд байрласан (дундаж хөрсний зузаан 3.46 м), баруун хойноос зүүн урагш сунаж тогтсон 1.13 км орчим урттай бөгөөд хамгийн өргөн нь нөөцийн 13-B-7 блокийн заагт 83.27 м, хамгийн нарийн нь ордын 17-B блокд 39.08 м байна. Ордын хувь цэвдэг болон бул чулуу байхгүй уул – техникийн хувьд ямар нэг хүндрэл байхгүй болно.

Ордын сунал болон хөндлөн чиглэлд алт агуулсан давхарга, алтны агуулгын өөрчлөлт, ордод хийгдсэн геологийн судалгааны ажлын түвшин, орд нь дунд хэсэгтээ салаалсан байдал, бага нөөцтэй зэргээрээ уг орд нь алтны шороон ордын нөөцийн ангиллаар II бүлэгт хамаарагдана. Үлдэгдэл нөөцийн хувьд хучаас хөрсний зузаан нь дунджаар 3.45 м, давхаргын дундаж зузаан нь 1.1 метр, 978.75 мг/м³ дундаж агуулгатай нийт 107.66 мян.м³ элс, 93.03 кг (хими цэвэр) алтны нөөцтэй байна.

2.6 Техник технологийн сонголт

Ил уурхайн механикжуулалт: Ил уурхайд ажиллах утгуурт ачигчийн утгуурын багтаамж (экскаватор, утгуурт ачигч) тээврийн хэрэгслийн тэвшний багтаамжийн харьцааг зөв сонгон авах нь үйлдвэрийн технологи болон эдийн засгийн үзүүлэлтүүдэд ихээхэн ач холбогдолтой байдаг. Компанийн өөрийн үндсэн тоног төхөөрөмж болох DEAWOO, SOLAR300LC экскаватор дээр тулгуурлан автосамосвал, мөн төсөл захиалагчийн ажлын даалгавар дээр тулгуурлан бусад тоног төхөөрөмжүүдийг сонгосон.

Ухаж-ачих тоног төхөөрөмж, ажиллах нөхцөл: Ухаж-ачих процессыг экскаватор–автотээврийн хослолоор гүйцэтгэх ба экскаватор нь мөчлөгийн ажиллагаатайгаас гадна түүний арга хэлбэр нь уул техникийн төрөл бүрийн нөхцөлд нийлэмж сайтай хэвшмэл арга юм. Бага хүчин чадлын уурхайд урвуу утгуурт экскаваторыг үндсэн төхөөрөмжөөр хэрэглэхэд тохиромжтойгоос гадна туслах ажиллагаанд ашиглах боломжтой.

Уурхайн тээврийн төрөл зүйл: Уурхайн тээврийн хувьд автотээвэр тохиромжтой бөгөөд уул геологийн ямар ч нөхцөлд хэрэглэх боломж харьцангуй өндөр, ямар ч физик-механикийн шинж чанартай чулуулгийг тээвэрлэх боломжтой, ашигт малтмалыг ангилан ялгаж олборлох боломж сайтай, хөрөнгө оруулалтын хэмжээ харьцангуй бага зэрэг давуу талыг үндэслэн сонгов.

Овоолгод ажиллах тоног төхөөрөмж: Бульдозерын тусламжтай овоолгын ажил явуулах аргыг сонгосон ба энэ нь автотээвэртэй ашиглалтын системтэй хосолдог ба бульдозер



нь овоолгын ирмэг ба талбайн зарим хэсэгт буй чулуулгийг түрж буулгахын зэрэгцээ овоолгын дээд талбайг тэгшлэх ба автосамосвалын явах замыг засаж бэлтгэдэг зэрэг давуу талтай.

2.7 Тухайн жилийн уулын ажлын төлөвлөлт

Ордыг ил уурхайн аргаар экскаватор автотээвэртэй ашиглалтын системээр уур амьсгалын байдалд үндэслэн уулын ажлыг цас ханзарч газар гэсэх үеэс цас орох хүртэл буюу 5-р сарын 20-оос 11-р сарын 1 хүртэл явуулах боломжтой гэж үзлээ. Уулын бэлтгэл ажлыг 5-р сарын 20-оос 25 хүртэл, хөрс хуулах ажлыг 6-р сарын 1-ээс 10-р сарын 15 хүртэл, элс олборлох ажлыг 5-р сарын 10-аас 10-р сарын 20 хүртэл, элс угаах ажлыг 6-р сарын 15-аас 10-р сарын 15 хүртэл явуулахаар төлөвлөж байна.

13-в-6, 13-в-5, 12-в-3 гэсэн 3 хэсгүүдэд үйл ажиллагаа явуулах ба 46 мян.м3 хөрс хуулан , 11.6 мян.м3 элс баяжуулан, хими цэвэрээр 5.93 кг металл худалдан борлуулахаар төлөвлөж байна.

ГУРАВ. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ, ҮНЭЛГЭЭ

Тус бүлэгт төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд, түүнд өртөх байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүд, тусгай хамгаалалттай газар нутаг, түүх, соёлын дурсгал, төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн иргэдийн нийгмийн байдал, эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллийг чиглэл тус бүрээр тооцож, мөн тэдгээр гол болон болзошгүй сөрөг нөлөөллийн эрчим, тархалт, хэмжээг тодорхойлж, тоон ба чанарын үнэлгээ өгсөн.

3.1 Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөллийг үнэлсэн арга зүй

“Мод мухар” алтны шороон ордыг ил аргаар ашиглах төслийн байгаль орчинд үзүүлэх гол ба болзошгүй сөрөг нөлөөллийн үнэлгээг БОНУ-нд хийгдсэн ба, төлөвлөгөөг боловсруулахдаа төсөл хэрэгжих талбайн байгаль орчны өнөөгийн төлөв байдал, ашиглах технологи, ашиглалтын параметрууд, төслийн үйл ажиллагаанд хамаарах хууль эрх зүйн орчин, нийгэмд үзүүлэх эдийн засгийн үр өгөөж зэргийг үндэслэл болгосон.



Хүснэгт 2. Нөлөөллийн үнэлгээний систем

Нөлөөллийн эрчим	Үргэлжлэх хугацаа	Хамрах хүрээ	Магадлал						
10 - Маш их	5 – Байнгын (30-дээш жил)	5 - Олон улсын хэмжээнд	5 - Гарцаагүй						
8 - Их	4 - Урт хугацааны (15-30 жил)	4 - Үндэсний хэмжээнд	- Өндөр магадлалтай						
6 - Дунд	3 - Дунд хугацааны (5-15 жил)	3 - Бүс нутгийн хэмжээнд	3 - Дунд магадлалтай						
4 - Бага	2 - Богино хугацааны (0-5 жил)	2- Орон нутгийн хэмжээнд	2 - Бага магадлалтай						
2 - Маш бага	1 - Түр зуурын	1- Тухайн орчны хэмжээнд	1 - Тохиолдохгүй						
0 – Нөлөөлөлгүй									
Хамгийн өндөр оноо 25 болох бөгөөд түүнийг 100 % гэж үзвэл									
<table border="0"> <tr> <td>>75 %</td> <td>Нөлөөллийн зэрэглэл өндөр</td> </tr> <tr> <td>40 %- 75 %</td> <td>Нөлөөллийн зэрэглэл дунд</td> </tr> <tr> <td><40 %</td> <td>Нөлөөллийн зэрэглэл бага</td> </tr> </table>				>75 %	Нөлөөллийн зэрэглэл өндөр	40 %- 75 %	Нөлөөллийн зэрэглэл дунд	<40 %	Нөлөөллийн зэрэглэл бага
>75 %	Нөлөөллийн зэрэглэл өндөр								
40 %- 75 %	Нөлөөллийн зэрэглэл дунд								
<40 %	Нөлөөллийн зэрэглэл бага								

Нөлөөлөл тус бүрт эдгээр хүчин зүйлүүдийг эрэмбэлсний дараагаар үүсэх магадлал ба хор уршиг гэсэн 2 зүйлийн зэрэглэлийг доорх томъёог ашиглан тооцно:

$$\text{Оноо} = (\text{Эрчим} + \text{Үргэлжлэх хугацаа} + \text{Хамрах хүрээ} + \text{Магадлал})$$

Онооны зэрэглэлийн хамгийн их утга нь 100%-тай тэнцүү байна. Байгаль орчны боломжит нөлөөллүүдийг бууруулах арга хэмжээтэй уялдуулан Их, Дунд зэрэг, Бага гэж дараах байдлаар зэрэглэн ангилна.

Хүснэгт 3.Нөлөөллийг үнэлэх

>75%	БО-нд нөлөөлөх зэрэглэл өндөр (Н) байгааг илтгэх	Энэ тохиолдолд ямар бууруулах арга хэмжээ байж болох вэ гэдгээс үл хамааран энэ нь төслийг эхлүүлэх эсэх талаар шийдвэр гаргахад нөлөөлнө.
30-75%	БО-нд үзүүлэх нөлөөлөл Дунд зэрэг (М) байгааг илтгэх	Бууруулах арга хэмжээ төлөвлөхгүй л бол энэ нь төслийг эхлүүлэх шийдвэрт нөлөөлнө. Дунд зэрэглэлийн нөлөөлөл нь менежментийн төлөвлөгөө гаргахыг зайлшгүй шаарддаг. Хэрэв менежментийн төлөвлөгөө боловсруулахгүй бол төслийг эхлүүлэх эсэх талаарх шийдвэрт ч нөлөөлж болзошгүй.
<30%	БО-нд үзүүлэх нөлөөллийн зэрэглэл Бага (L) байгааг илтгэх	Төслийг эхлүүлэх эсэх талаарх шийдвэрт нөлөө үзүүлэхгүй. Маш бага нөлөөлөл нь төслийн төлөвлөлт, дизайнд өөрчлөлт оруулахад хүргэдэггүй бөгөөд бууруулах арга хэмжээний өөр хувилбаруудыг ашиглах шаардлагагүй байдаг.
-	Нөлөөгүй	Нөлөөлөлгүй буюу байхгүй байгааг илэрхийлнэ.

3.2 Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөллийн үнэлгээ

Төслөөс байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг тодорхойлохдоо уурхайн өмнөх жилүүдийн олборлолтын үйл ажиллагаанаас уурхайн талбайд одоо үүсээд байгаа сөрөг нөлөөлөл болон ашиглалтын дараа дараагийн жилд үүсэж болзошгүй сөрөг нөлөөллийг тодорхойлсон байна.



Уурхайн олборлолтоос үүсэж болзошгүй сөрөг нөлөөллийг Матрицын аргаар үнэлсэн бөгөөд нөлөөлийн хэмжээг 1-10 баллаар үнэлэн /1 нөлөөлөл хамгийн бага байх утга 10 нөлөөлөл хамгийн их утга/ төслийн болзошгүй сөрөг нөлөөллийг нийт үзүүлэлтүүдийн дундажтай харьцуулан гаргасан.

Хүснэгт 4.Төслөөс үүсэж болзошгүй сөрөг нөлөөлөл

Байгалийн хүчин зүйлс			Уурхайн олборлолт /элс угаах, хөрс хуулалт/	Уурхайн тосгон, засвар	Уурхайн хог хаягдал хаях цэг, эрүүл ахуйн бүс	Тунаах нуур	Уурхайн дотоод, гадаад тээвэр	Хүнд оврын машин техникийн засвар үйлчилгээ	Шагах тослох материалын алдагдал, үүсэх хий	Уурхайн гадаад дотоод овоолго	Нийт /баллын дундаж/	
Физик орчин	Хөрсөн бүрхэвч	Хөрс, газрын хэвлийн доройтол	7	8	8	9	7	5	1	7	7	
		Хөрсний бохирдол	6	9	8	7	5	7	1	5	6	
		Геоморфологийн өөрчлөлт	7	2	2	8	4	1	0	2	3	
	Усан орчин	Гол, булаг шандны гольдрилын өөрчлөлт	8	1	1	5	3	1	0	1	3	
		Гадаргын болон гүний усны бохирдол	8	4	8	4	2	6	8	1	5	
		Усны нөөц багасах	7	2	1	6	1	1	0	1	2	
		Газрын гадаргын бага гүнд орших уст давхарга	9	1	6	7	1	2	0	4	4	
	Агаарын чанар	Агаарын чанар	8	6	7	4	8	4	8	4	4	
		Үнэр	0	1	8	1	2	4	6	1	3	
		Дуу чимээ	9	2	0	0	8	2	0	0	2	
	Биологи орчин	Ургамлан нөмрөг	Ой	0		0	0					0
			Бэлчээр	6	5	2	4	5	2	1	2	3



		Ургамлын зүйлийн бүрэлдэхүүн	9	7	7	8	8	4	2	6	6	
		Ургамлын өсөлт хөгжилт	8	2	5	4	4	4	1	2	4	
	Амьтны аймаг	Хөхтөн амьтад	2	1	1	1	2	1			1	
		Мөлхөгчид	8	1	2	5	6	2	5	6	4	
	Экосистем	Экосистемийн доройтол	8	1	1	2	6	1	1	2	3	
Нийгэм	Газар ашиглалт	Хөдөө аж ахуйн эдэлбэр газар	7	1	2	5	6	1	1	4	3	
		Ландшафтын өөрчлөлт /байгалийн төрх байдал /	7	1	2	8	4	2	1	4	4	
	Түүх соёлын өв	Түүх соёлын дурсгалт зүйл	0	0	0	0	0	0	0	0	0	
		Археологи палеонтологийн өв	0	0	0	0	0	0	0	0	0	
	Нийгэм	Хүн амын нягтшил	0	1	0	0	0	0	0	0	0	
		Ажлын байр	0	0	0	0	0	0	0	0	0	
		Байгалийн гамшигт үзэгдэл	7	0	2	4	4	1	1	2	3	
	Нийт /баллын дундаж/			5	2	3	4	4	2	2	2	3

Сөрөг нөлөөллийн эрчим	Сөрөг нөлөөлөл их /7-10 балл/	Нөлөөлөл дунд зэрэг /4-6 балл/	Нөлөөлөл бага /1-3 балл/
Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчны параметруудэд үзүүлэх сөрөг нөлөөлөл	Уурхайн олборлолт /элс угаах, хөрс хуулалтын үйл ажиллагаа/	Уурхайн хог хаягдал хаях цэг, эрүүл ахуйн бүс	Хүнд оврын машин техникийн засвар үйлчилгээ
		Тунаах нуур	Шатах тослох материалын алдагдал, үүсэх хий
		Уурхайн дотоод тээвэр	Уурхайн гадаад дотоод овоолго үүсгэх үйл ажиллагаа
			Уурхайн тосгон, засвар механикын цех

Сөрөг нөлөөлөл их /7-10 балл/: Уурхайн олборлолтын үндсэн үйл ажиллагаа болох элс угаах, хөрс хуулалтын нөлөөгөөр хөрсөн бүрхэвч, газрын хэвлий их хэмжээгээр эвдрэлд орох, элс



угаах үйл явцаас усны нөөц багасах, уурхайн тээвэр, олборлолтоос агаарт тоосжилт, дуу чимээ үүсэх, ашиглалт явагдаж байгаа талбайн ургамлан нөмрөг бүхэлдээ устах, хөрс газрын хэвлийг шүтэн амьдардаг микро организмууд устах, хөрсний гулсалт нуралт үүсэх зэрэг болозошгүй сөрөг нөлөөлөлүүд үүсэж болзошгүй байна.

Сөрөг нөлөөлөл дунд /4-6 балл/: Хог хаягдал хаях цэг, уурхайн тунаах нуур үүсгэх зэргээс хөрс, усны бохирдол үүсэх, агаарын чанарт нөлөөлөх, уурхайн тээврийн зам дагуух хөрсөн бүрхэвч элэгдэлд орох, тунаах нуурын орчимд гадна хашлага хаалт хийгээгүйгээс мал амьтан унаж үрэгдэх, уурхайн карьерын доголын өндөр нь стандартын бус байснаас мал амьтан унах, хөрсний нуралт гулсалт үүсэх зэрэг сөрөг нөлөөллүүд үүсэж болзошгүй байна.

Сөрөг нөлөөлөл бага /1-3 балл/: Машин техникийн засвар үйлчилгээний цэг, шатах тослох материал хөрсөнд нэвчих, шимт хөрсний гадаад дотоод овоолгоос эрүүл газар доройтох, нөхөн сэргээлтийг аргачлалын дагуу хийгээгүйгээс бэлчээр нутаг хумигдах цаашлаад тухайн орчинд экосистемийн доройтол үүсэж болзошгүй байна.

3.3 Төслийн гол сөрөг нөлөөлөл

Уурхайн ашиглалтын үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх гол сөрөг нөлөөллүүд нь:

- Уурхайн үйл ажиллагаа, олборлолт, бүтээн байгуулалттай холбоотойгоор 19.44 га талбайн газрын гадарга эвдрэлд өртөх, карьер үүсэх
- Хүнд оврын машин механизм, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөг талхлагдах
- Элс угаах үйл явцын дараах эфель, гаалийн хаягдал овоолго үүсэх
- Уурхайн бүтээн байгуулалт, уурхайн олборлолтын талбай, тунаах нуур зэргээс нийт 19.44 га талбай эвдрэл элэгдэлд орно.

Иймд MV-007104 тоот ашиглалтын лиценз бүхий “Мод мухар” нэртэй алтны шороон ордыг ил аргаар ашиглах төслийн БОНБНУ-ний тайланд тусгасан сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний зөвлөмж хэсэг мөн байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгасан үйл ажиллагааг мөрдөж ажилласнаар уурхайн үйл ажиллагааг байгаль орчинд сөрөг нөлөөлөл багатай байдлаар явуулах бүрэн боломжтой гэж үзэж байна.



Хүснэгт 5. Уурхайн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх гол сөрөг нөлөөлөл, өртөх орчин, нөлөөллийн эрчим

№	Төслийн гол нөлөөлөл	Нөлөөлөлд өртөгч	Хамрах хүрээ	Нөлөөллийн эрчим	Хугацаа
1	2	3	4	5	6
1	Уурхайн карьер, олборлолтын талбайн хөрсөн бүрхэвч, газрын гадарга эвдрэлд орох	Орчны хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөг	0-19.44 га	Их	Хавар, намар, зуны улиралд
2	Газрын хэвлий, ландшафтын өөрчлөлт	Хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөг, газрын хэвлий	10 га <	Их	Уурхайн олборлолтын явцад
3	Уурхайн ойр орчимд зам ихсэх, олон салаа зам үүсэх	Хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөг	Уурхайн олборлолтын талбайн ойр орчимд	Их	Уурхайн олборлолтын явцад
4	Хөрс хуулалт хийж автосамосвалаар элс угаах скруббер хүртэлх тээвэрлэлтийн үед тоосжилт үүсэх	Ургамлан нөмрөг, агаар орчин	0-1.5 га	Их	Уурхайн олборлолтын хугацаанд
5	Үер ус, хөрсний гулсалт үүсэх	Уурхайн олборлолтын талбай, уурхайн тосгон	0-10 км ² түүнээс их	Хүчтэй	Тогтоох боломжгүй



Хүснэгт 6. Нийт сөрөг нөлөөллийн үнэлгээний дундаж

Байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүд	Нөлөөллийн үр дагаврын үнэлгээ			
	Бага	Дунд	Их	Аюултай
1. Байгаль орчин				
Агаар орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл	0	52.0	0	0
Гадаргын ба газрын доорх усанд үзүүлэх сөрөг нөлөөлөл		65.0	0	0
Газрын гадарга, хөрсөн бүрхэвчид үзүүлэх нөлөөлөл	0	68	0	0
Ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөлөл	0	61	0	0
Амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөлөл	0	57	0	0
Тусгай хамгаалалттай газар нутаг, түүх соёлын дурсгалд үзүүлэх сөрөг нөлөөлөл	32	0	0	0
Эзлэх хувь /дунджаар/		55.8		
2.Эерэг нөлөөлөл				
Төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн иргэдийн нийгмийн байдал, эрүүл мэндэд үзүүлэх нөлөөлөл	0	0	75.6	0
Сөрөг нөлөөллийн үнэлгээний дүгнэлт	<p>Төслийн үйл ажиллагаа хэрэгжих явцад байгаль орчин, нийгэмд учруулах нөлөөллийн үр дагаврын үнэлгээг экосистемийн үндсэн 7 бүрэлдэхүүн хэсэгт хувааж тус бүрийн нөлөөллийн үнэлгээг тооцож гаргасан.</p> <p>Дээрх бүгдээс үзэхэд тус төсөл хэрэгжсэнээр байгаль орчинд учруулах нийт сөрөг нөлөөллийн үнэлгээний дундаж 55.8 % буюу Дунд зэргийн нөлөөлөл учруулж болзошгүй байна.</p>			



ДӨРӨВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

4.1 Эрх зүйн үндэслэл ба түүний гол шаардлага

2012 онд шинэчлэн батлагдсан байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, 2019 онд батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-д зааснаар “Өгөөмөр Өргөө” ХХК-ийн “Мод мухар” нэртэй алтны шороон ордыг ил аргаар ашиглах төслөөс тухайн нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд үүсэж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх зорилгоор байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулан батлуулж хэрэгжилтийг хангаж ажиллах үүрэг нь төсөл хэрэгжүүлэгч “Өгөөмөр-Өргөө” ХХК-д тавигдаж байна.

Иймд шинэчлэн батлагдсан хууль, журам, аргачлалын дагуу дагуу уг алтны шороон ордыг ил аргаар ашиглах төслийн үйл ажиллагааны явцад баримтлах байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулсан. Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах болон нөхөн сэргээлт хийх журам, аргачлалыг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, нөхөн сэргээлтийн стандартыг холбогдох хууль тогтоомжийн дагуу эрх бүхий байгууллага тус тус батлан мөрдүүлнэ.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь

- Байгаль хамгаалах төлөвлөгөө
- Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр

гэсэн үндсэн хоёр хэсгээс бүрдэх бөгөөд байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг багасгах, арилгах арга хэмжээ, дүйцүүлэн хамгаалал хийх, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах хөрөнгө зардлыг тусгасан. Харин орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрт төслийн үйл ажиллагааны улмаас байгаль орчны төлөв байдалд үзүүлж буй өөрчлөлтийг хянах, шинжилгээ хийх, үр дүнг тайлагнах, түүнийг хэрэгжүүлэх арга хэлбэр, шаардагдах хөрөнгө, зардал, хугацааг тодорхойлон тусгахаар хуульчлагдсаныг баримтлан БОМТ болон ОХШХ-ийг боловсруулсан.

Нөгөө талаас “Мод мухар” нэртэй алтны шороон ордыг ил аргаар ашиглах төслийг хэрэгжүүлэгч “Өгөөмөр-Өргөө” ХХК нь байгаль орчныг хамгаалах талаар хүлээсэн үүргээ биелүүлэх баталгаа болгож, байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын буюу БОАЖЯ-ны нөхөн сэргээлтийн тусгай дансанд ашиглалтын үйл ажиллагаа



дуусах хүртэл жил бүр тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын 50 хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг төвлөрүүлнэ. Хэрвээ “Өгөөмөр-Өргөө” ХХК нь байгаль хамгаалах талаар хуулиар хүлээсэн үүргээ хангалттай биелүүлж, жил бүрийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг биелүүлсэн бол Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 14.1.3-т заасан хаалтын менежментийн төлөвлөгөөний биелэлтийн явцыг үндэслэн мөн хуулийн 9.10-т зааснаар хуримтлагдсан хөрөнгийг тодорхой хуваарийн дагуу буцаан олгохоор зохицуулагдсан.

Гэхдээ БОАЖЯ байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилт, нөхөн сэргээлтийн ажлын гүйцэтгэл болон тус хуулийн 9.12-т зааснаар хянуулсан хяналтын дүнд хөндлөнгийн хяналт хийлгэж, дүгнэлт гаргуулах бөгөөд уг дүгнэлт төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг үндэслэн баталгааны мөнгийг буцаан олгох эсэх асуудлыг энэ тухайн хуулийн 9.15-д заасан байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн тусгай дансны гүйлгээнд хяналт тавих журмын дагуу шийдвэрлэх юм.

Төслийг хэрэгжүүлэгч “Өгөөмөр Өргөө” ХХК нь тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг **жил бүрийн 11 дугаар сард** багтаан харьяа орон нутгийн БОАЖЯ-д хүргүүлж дараа оны тухайн оны техник болон биологийн нөхөн сэргээлтийг газар дээр шалгуулж акт үйлдүүлнэ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтэд тухайн орон нутгийн байгаль хамгаалагч, байгаль орчны хяналтын улсын байцаагч, бүх шатны засаг дарга, төрийн захиргааны төв байгууллага болон байгаль орчны төрийн бус байгууллага хяналт тавих эрхтэй бөгөөд тэдгээрт холбогдох мэдээллээ ил тод болгох, тодорхой хуваарийн дагуу хяналт хийх боломжийг бүрдүүлэх шаардлага мөн тавигдсан.

4.2 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зорилго, хамрах хүрээ

Төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилтуудыг байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний үр дүнгүүд болон Байгаль орчин, Аялал жуулчлалын яамны уг төсөлд хийсэн ерөнхий үнэлгээний дүгнэлтэд заасан шаардлагуудад үндэслэн тодорхойлсон. Мөн УИХ-аар хэлэлцэн баталсан байгаль орчны багц хуулиуд тухайлбал, Байгаль орчныг хамгаалах тухай, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай, Усны тухай, Ус бохирдуулсны төлбөрийн тухай, Хөрс хамгаалах, Цөлжилтөөс сэргийлэх тухай, Ургамал хамгааллын тухай, Амьтны тухай, Агаарын тухай, Хог хаягдлын тухай, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай зэрэг хуулиуд түүнтэй холбогдох бусад хуулиудад орсон



өөрчлөлтүүд ялангуяа аж ахуйн нэгжийн байгаль хамгаалах талаар хүлээх үүргүүдийг тусгасан болно.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлж ажилласнаар уурхайн олборлолтын үед гарч болзошгүй сөрөг үр дагавраас урьдчилан сэргийлэх, бий болсон сөрөг үр дагаврыг тухай бүрт нөхөн сэргээх замаар төслийг байгаль орчинд ээлтэйгээр хэрэгжүүлэх боломжтой юм.

БОМТ-г хэрэгжүүлснээр дараах зорилтууд хангагдана. Үүнд:

- Монгол улсын БОАЖЯ-наас тавьж буй байгаль орчныг нөхөн сэргээх болон сөрөг нөлөөллийг бууруулах талаар тавьж буй шаардлагыг хангасан байх;
- Төслийг хэрэгжүүлэх, үйл ажиллагааны шат дамжлага бүрт технологийн журам зааврыг байгаль хамгаалах хууль тогтоомжийн холбогдох зүйл заалт, стандарт шаардлагад нийцүүлэх;
- Байгаль орчны менежментийн талаар БОНБНҮ-ээр дэвшүүлсэн зорилго зорилтыг хэрэгжүүлэх, зөвлөмжийг биелүүлэх;
- Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх болон байгаль орчны сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний талаар холбогдох ажилтнуудад зориулан товч, тодорхой зааварчилгаа өгөх;
